



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 598

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудын албан ажлын хэрэгцээнд зориулан улсын төсвийн ба нийслэлийн хөрөнгө оруулалтаар болон "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компанийн батлагдсан санхүүжилтийн эх үүсвэрээр нийт 1,567,200,000.00 (нэг тэрбум таван зуун жаран долоон сая хоёр зуун мянган) төгрөгт багтаан 18 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 4 дугаар сарын 22 ны өдрийн
598 дугаар тогтоолын хавсралт



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ
АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Киа K2700, 2 хүний суудалтай, 2665 cc ачааны хөргүүртэй	1	110,000,000.00	110,000,000.00
2	Мотоцикл, FE-350 350 cc	4	38,500,000.00	154,000,000.00
3	Чиргүүл (бага оврын)	2	13,000,000.00	26,000,000.00
4	Тоёота ландкрузер-76, 9 хүний суудалтай, 4200 cc	1	121,200,000.00	121,200,000.00
5	Тоёота ландкрузер-76, 9 хүний суудалтай, 4164 cc	1	123,000,000.00	123,000,000.00
6	Тоёота ландкрузер-76, 9 хүний суудалтай, 4164 cc	1	130,800,000.00	130,800,000.00
7	Тоёота ландкрузер-78, 11 хүний суудалтай, 4164 cc	1	119,900,000.00	119,900,000.00
8	Тоёота ландкрузер-78, 11 хүний суудалтай, 4164 cc	1	130,000,000.00	130,000,000.00
9	Тоёота ландкрузер-78, 11 хүний суудалтай, 4164 cc	2	121,700,000.00	243,400,000.00
10	Тоёота ландкрузер-79, 5 хүний суудалтай, 4164 cc	2	109,100,000.00	218,200,000.00
11	Хьюндай HD-65 ачааны 3.5 тн 3980 cc	1	152,000,000.00	152,000,000.00
12	Мотоцикл (4 дугуйт)	1	38,700,000.00	38,700,000.00
	Нийт дүн	18		1,567,200,000.00